

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэрэндоржийн Шархүү	Дугаар	L063
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Халхгол сум
Төрсөн газар	Хөвсгөл аймгийн Улаан-Уул	Төрсөн он	1943
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Эрхэмсэг бэйсийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ДОХГ 047
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Халхгол сумын Эрхэмсэг бэйсийн хүрээ

Танай Халхгол сумд ямар ямар хийд байв?

Эрхэмсэг бэйсийн хүрээ нь Өлзийт гэдэг газар байсан гэсэн. Баруун тийшээ Буриад дуган 8 орчим км-т бий. Баян цагаан талын урд Ламын хайрханы тэнд Авдрантын заставын тэнд Ламын Хайрханы урд Ламын хийд гэж байсан.

-Сангийн далайн тэнд хийд байсан уу?

Тэрийг бид орон нутаг хол учраас мэдэхгүй байна. Ёнгор хавьцаа нэг хийд байсан юм уу хаашаа юм. Хулстайн хийд. Тамсагаас нэлээд наана. Эндээс 90-ээд км байгаа байх. Хулстай гэдэг нь хойд талдаа. Ёнгор гэдэг нь урд талдаа. Ёнгорын хийд гэж нэлээд бага хийд нэг цагаан хамар дээр байсан юм уу. Өөр юм мэдэхгүй.

Хэрээ уулын тэнд хийд байсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хойд талд нь Дунгар Гулбаа ноёны туйр гэж нэг газар байдаг. Дунгар Галбаа ноён гэж буриадын нэг ноён байсан. Тэр хүний өвөлжөөний газар байсан юм уу.Тэр хүний мэдлийн хийд байсан юм уу. Овоолсон нэг хөшөө чулуу шиг юм байдаг юм. Хэрээ уулын яг тушаа харалдаа.

-Тэр чинь То вангийн Өвлийн Поврон ордон байгаагүй юм уу?

Биш. Манай эндхийхэн чинь юм л бол овоолсон шороо байсан ч То вангийнх гэдэг. Газраа буруу буруу нэрлээд. Нэг л аятайхан юм байвал энэ То вангийн гэж нэрлэдэг. То ванг Хэрлэн Барс хотыг даргалаж байсан гэвэл энд юу боллоо гэж өвлийн ордоо энд барих вэ гэж л бодож байна. Яаж мэдэхэв дээ.

Сангийн далай, Жамсран овооны тэнд хийд байсан юм уу?

Тэрийг би сайн мэдэхгүй байна. Би Хөвсгөлийн Улаан-Уул сумын хүн. Энд суурьшаад 37,38 жил болчихлоо доо.